

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА ЭРХЭМБАЯРЫН БАТТУЛГЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилт хэрэгжүүлэх арга	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин биелэлт	Эхлэх, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Гүйцэтгэлийн зорилт 1. Улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник, технологийн шинэчлэл хийх							
1	Арга хэмжээ 1. Аэрологийн 2 станц байгуулан урьдчилан мэдээлэх чадварыг бэхжүүлнэ.	Шинээр байгуулсан аэрологийн станц тоо	-	Өвөрхангай аймагт Аэрологийн станцыг шинээр ашиглалтад оруулж, туршилтын хөөргөлтийг эхлүүлнэ.	БНСУ-ын Цаг уурын албаны буцалтгүй тусламжаар Өвөрхангай аймгийн УЦУОШТөвд аэрологийн шинэ системийг суурилуулж дууссан бөгөөд 2026 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд БНСУ-ын Цаг уурын албаны Дэд даргаар ахлуулсан мэргэжилтнүүд Монгол Улсад ажиллан, төслийн хаалтыг хийж, системийг албан ёсоор хүлээлгэн өгсөн. Туршилтын хөөргөлтийг 2026 оны 05 дугаар сард 3 удаа амжилттай хийсэн ба 6 дугаар сард багтаан хөтөлбөрийн дагуу хөөргөлт хийхэд бэлэн болсон.	1-6 сар	100%
2	Арга хэмжээ 2. Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх Доплерын радарын станцыг Өвөрхангай, Ховд аймагт байгуулах	Радарын станц байгуулсан аймаг, тоо	1 (Улаанбаатар хот)	Өвөрхангай, Ховд аймагт радарын станц байгуулах худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.	ЦУОШГ-ын Улсын сүлжээний газраас Доплерын суурин радарын техникийн тодорхойлолт болон ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, БОУАӨЯ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн бөгөөд тус газраас БОУАӨЯ/20260102009 дугаартай "Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх	1-6 сар	100%

					<p>Доплерын радарын станц /Өвөрхангай, Хархорин сум, Ховд, Буянт сум/" нэр бүхий бараа худалдан авах цахим тендерийг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр "Саммит" ХХК шалгарсан.</p> <p>https://user.tender.gov.mn/mn/result/detail/1775584140439</p> <p>БОУАӨЯ-ны 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 03/3292 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу "Саммит" ХХК-тай Өвөрхангай, Ховд аймагт Доплерын радарын станц байуулах УТ2601300863001, УТ2601300863002 дугаартай гэрээнүүдийг байгуулж, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахимд системд бүртгэн оруулсан.</p>		
3	Арга хэмжээ 3. Ус судлалын 80 харуулыг автоматжуулах	Автоматжуулсан усны харуул, өссөн дүнгээр	17	Төсвийн эх үүсвэрийг шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	<p>БОУАӨСайдын төсвийн багцаас 5 ширхэг ус судлалын автомат станцыг худалдан авах зорилгоор 500 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.</p> <p>ЦУОШГ-ын Улсын сүлжээний газраас ус судлалын автомат станцын техникийн тодорхойлолтыг боловсруулан батлуулж, БОУАӨЯ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр БОУАӨЯ/20230102007 дугаартай "Ус судлалын автомат станц /5 ширхэг/" нэр бүхий бараа худалдан авах цахим тендерийг зарлаж, гүйцэтгэгчээр "Мейжүрмент" ХХК шалгарсан.</p> <p>"Мейжүрмент" ХХК-тай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын тоног төхөөрөмж худалдан авах УТ2601300929002 дугаартай гэрээг 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан.</p>	1-6 сар	100%

					https://user.tender.gov.mn/mn/result/detail/1770779070938		
4	Арга хэмжээ 4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг мөндөр, манан сарниулах чиглэлд өргөжүүлэх хүрээнд шинээр явуулын радар, газрын генератораар хангах	Шинээр байгуулах явуулын радарын тоо	-	Явуулын радар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.	ЦУОШГ-ын Улсын сүлжээний газраас явуулын радарын техникийн тодорхойлолт болон ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, БОУАӨЯ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас БОУАӨЯ/20260102011 дугаартай "Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх явуулын радар, Цахилгаан нөөц дизель станц" нэр бүхий бараа худалдан авах цахим тендерийг 2026 оны 04 дүгээр сарын 23 болон 05 дугаар сарын 26-ны өдөр 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй байна. 2027 оны улсын төсвийн төсөлд тусгуулахаар саналыг хүргүүлээд байна.	1-6 сар	30%
5		Шинээр суурилуулах газрын генераторын тоо	-	Газрын генераторыг худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.	ЦУОШГ-аас аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн хүсэлтийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр ЦУОШГ-ын харьяа Өмнөговь аймгийн УЦУОШТөв болон Баянхонгор аймгийн Бөмбөгөр суманд тус бүр 1 газрын генераторыг худалдан авсан. Мөн Завхан аймгийн УЦУОШТөвд газрын генераторын түлш худалдан авах "Говийн болон газар тариалангийн бүс нутагт үүл хуримтлуулах газрын генератор худалдан авах" ЗААХААГ/20260102070 дугаартай цахим тендер зарлагдсан. https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1773637383593	1-6 сар	70%
6	Арга хэмжээ 5. Олон улсад мэдээлэл солилцох станцын тоог 50-иас доошгүй хувиар нэмэгдүүлэх	Олон улсын мэдээлэл солилцоонд мэдээллээ гаргасан өртөөний тоо	63	Олон улсад мэдээлэл солилцох станцын тоог 80 хүргэсэн байна.	Дэлхийн цаг уурын байгууллагын OSCAR/Surface платформд 75 өртөөдийн мета өгөгдлийг шинээр бүртгүүлж, олон улсын мэдээ солилцоонд улсын сүлжээний бүх өртөө буюу 138 өртөөдийн мэдээ гарч эхэлсэн.	1-6 сар	100%

					Мөн Дэлхийн тоон прогнозын загварын 4 төвд 102 өртөөдийн мэдээ гарч байна.		
7	Арга хэмжээ 6. Цаг уурын өртөө, харуулуудад цаг уурын автомат станц суурилуулах	Цаг уурын улсын сүлжээнд суурилуулсан автомат станц, тоо	215	Төсвийн эх үүсвэрийг шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	ЦУОШГ, БНСУ-ын Байгаль орчны корпорацитай хамтран Улаанбаатар хотод 2026 онд цаг уурын үндсэн үзүүлэлт, агаарын чанарыг хэмших 3 ширхэг автомат станцыг 79, 133-р цэцэрлэг, Монгол Тэмүүлэл сургуулийн орчимд суурилуулахаар ажлыг 6-р сарын 9-нөөс эхлүүлсэн. 9-р сард хүлээн авна. ЦУОШГ-ын Улсын сүлжээний газраас цаг уурын автомат станцын техникийн тодорхойлолтыг боловсруулан, батлуулж, БОУАӨЯ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас "Цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх явуулын радар, Цахилгаан нөөц дизель станц худалдан авах" 3 багц бүхий БОУАӨЯ/20260101011 дугаартай цахим тендерийг 2026 оны 03 дугаар сарын 10, 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй байна. https://user.tender.gov.mn/mn/invitation/detail/1775584325542	1-6 сар	70%
8	Арга хэмжээ 7. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулах	Хөтөлбөр шинэчлэгдэнэ	2016 онд батлагдсан.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, ЦУОШГ-ын харьяа байгууллага УЦУОСМХ-ийн холбогдох хэлтсүүд болон аймаг, Нийслэлийн УЦУОШТ-үүдээс холбогдох саналыг авч нэгтгэн, цахим болон танхимын уулзалтыг 10 удаа зохион байгуулж ажилласан. Шаардлагатай саналуудыг тусган, "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажлын ажлын хөтөлбөр"-ийг боловсруулан батлуулахаар БОУАӨСайдад хүргүүлэхэд бэлэн	1-6 сар	30%

					болсон. 2026 оны 3 дугаар улиралд батлуулахаар төлөвлөж байна.		
9	Арга хэмжээ 8. Эрт сэрэмжлүүлгийн бүтээгдэхүүн боловсруулах: Ган, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний аргазүйг боловсруулах, турших	Аргазүй /туршилтын тоо	0/2	Ган, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний аргазүйг боловсруулж туршина.	Ган, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний аргазүйг боловсруулж, ЦУОШГ-ын харьяа байгууллага УЦУОСМХ-ийн Шинжлэх Ухаан Технологийн зөвлөл /ШУТЗ/-ийн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Гангийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний эхний үр дүнг байгаль цаг агаарын нөхцөлтэй уялдуулан 2026 оны 07 дугаар сард гаргана.	1-6 сар	100%
Гүйцэтгэлийн зорилт 2. Орчны чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх хөтөлбөр хэрэгжүүлэх							
10	Арга хэмжээ 1. Агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөн УБ хот болон 19 аймагт 4-6 үзүүлэлтээр агаарын чанарыг хэмжих	Суурилуулсан багажийн тоо	75 ширхэг багаж суурилуулсан.	Улаанбаатар хот, орон нутагт нэмэлт үзүүлэлт хэмжих хэрэгцээ шаардлагын судалгаа хийх, сонгогдох байршлыг тогтооно.	Улаанбаатар хот болон 21 аймагт суурилуулах Агаарын чанарын хяналт шинжилгээний автомат станцын нийт 25 төрлийн 78 ширхэг багаж, 86 төрлийн 657 ширхэг сэлбэг хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлүүлж, 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс хуваарийн дагуу суурилуулж эхэлсэн.	1-6 сар	100%

11	<p>Арга хэмжээ 2 Аймгийн төвүүдийн агаарын чанарын мэдээллийг иргэдэд нээлттэй, шууд хүргэх цахим платформыг ашиглалтад оруулах</p>	<p>Платформтой болсон байна</p>	<p>УБ-ын агаарын чанарыг мэдээлж байгаа</p>	<p>Улаанбаатар хот 21 аймгийн агаарын чанарын мэдээг шууд харах боломжтой болно.</p>	<p>Агаарын чанарыг автоматаар хянах багаж, тоног төхөөрөмжийг 21 аймгийн төвд суурилуулан, аймгийн төвүүдийн агаарын чанарын мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, шууд хүргэх www.agaar.gov.mn цахим платформыг 2026 оны 01 дүээр сарын 28-ны өдөр нээж, ашиглалтад оруулсан.</p> <p>Мөн Улсын сүлжээний агаарын чанарыг хянах шинжилгээний ажлыг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн автомат багажид шилжүүлэх тухай ЦУОШГ-ын даргын 2026 оны А/22 дугаар тушаал гарган, үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна.</p> <p>Агаарын чанарын дүн мэдээг боловсруулах MAMIS програм хөгжүүлсэнтэй холбоотойгоор агаарын чанарын дүн мэдээг боловсруулах, багаж, тоног төхөөрөмжийн тохируулга, үйлчилгээ хийх гарын авлага, заавар, зөвлөмжийг гарган хүргүүлж, мэдээ, мэдээллийн хэвийн, тасралтгүй ажиллагаа болон мэдээний чанарт хяналт тавьж, бодит хугацааны агаарын чанарын мэдээллээр тогтмол үйлчилж байна. / https://agaar.gov.mn/web/ /</p>	1-6 сар	100%,
12	<p>Арга хэмжээ 3. Орчны шинжилгээний салбарт мөнгөн уст бодисийн хэрэглээнээс бүрэн татгалзах технологийн шинэчлэлийг хийж автоматжуулах</p>	<p>Мөнгөн уст бодис хэрэглэхгүй</p>	<p>22 лабораторид хэрэглэж байгаа</p>	<p>22 лабораторид хориглосон шийдвэрийг гаргана.</p>	<p>Агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлоход мөнгөн усны ислийг ашигладаг байсан бөгөөд агентлагийн даргын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/22 дугаар тушаалаар Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн агаарын чанарыг автоматаар тодорхойлох болсноор мөнгөн усны ислийн хэрэглээг бүрэн халсан.</p>	1-6 сар	100%

13	Арга хэмжээ 4. Хөрсөн дэх хүнд металлыг 30-аас доошгүй үзүүлэлтээр тодорхойлох	Тодорхойлох үзүүлэлтийн тоо	7	Улаанбаатар хот болон 21 аймгаас 418 цэгээс хөрсний сорьц цуглуулах	Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн хөрснөөс нийт 415 цэгт хөрсний хяналт шинжилгээний сорьцыг 4-6 дугаар сард цуглуулж дууссан. Хүнд металлын 30 үзүүлэлт болон агро химийн шинжилгээний ажил 6-9 дүгээр сард хийгдэнэ.	1-6 сар	100%
----	--	-----------------------------	---	---	--	---------	------

Гүйцэтгэлийн зорилт 3. Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

14	Арга хэмжээ 1. Орчны чанарын 2024-2025 оны төлөв байдлын тайлан гаргах	Агаар, хөрс, ус, цацраг, агаарын бохирдлын эх үүсвэрийн төлөв байдлын тайлан	1	Монгол орны байгаль орчны чанарын 2024-2025 оны төлөв байдлын тайлан гарсан байна.	Монгол орны байгаль орчны төлөв байдлын 2024-2025 оны тайланд Улаанбаатар хот болон төв, орон нутгийн агаарын чанарын хяналт шинжилгээний 1-12 сарын мэдээ, мэдээллийг станц тус бүрээр нэгтгэн боловсруулж, өмнөх оны мөн үетэй харьцуулсан дүн шинжилгээ хийж, БОУАӨЯ болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/32 тоот албан бичгээр хүргүүлсэн. Монгол орны гадаргын усны жилийн төлөв байдлын тайланг боловсруулж, БОХЗТЛ-ийн 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 27 тоот албан бичгээр БОУАӨЯ-нд хүргүүлсэн. Гадаргын усны хяналт шинжилгээний дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/332 дугаар тушаалаар батлагдсан "Усны чанарын индекс"-ээр үнэлэхэд хяналт шинжилгээний 146 цэгээс 92 цэг буюу 63 хувь нь "Маш цэвэр", 38 цэг буюу 26 хувь нь "Цэвэр", 10 цэг буюу 6.8 хувь нь "Бага бохирдолтой", 1 цэг буюу 0.7 хувь нь "Бохир", 5 цэг буюу 3.4 хувь нь "Маш бохир" ангилалд үнэлэгдсэн байна. Туул голын Сонгино дээд, Сонгино доод, Хадан хясаа, Төв аймгийн Алтанбулаг орчмын цэгүүдэд "Бохир" болон "Маш бохир" ангилал тогтоогдсон	1-6 сар	100%
----	--	--	---	--	--	---------	------

					<p>бол Хиагт-Алтанбулаг, Сэлбэ гол, Дунд гол, Орхон аймгийн Хангал, Уртбулаг, Сэлэнгэ аймгийн Хөх нуур, Шарын гол, Сүхбаатар аймгийн Ганга нуур, Говьсүмбэр аймгийн Хаялга нуур зэрэг цэгүүдэд "Бага бохирдолтой" ангилалд тогтоогдсон.</p> <p>Улаанбаатар хотын өнгөн хөрсний хүнд металлын агууламжийг Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 5850:2019)-тэй харьцуулан үнэлэхэд нийт хяналт шинжилгээний цэгийн 21.5 хувь буюу 22 цэгт бохирдол илэрсэн. Үүнээс хар тугалгын агууламж 6.5 хувь, цайрын агууламж 13.1 хувь, кадмийн агууламж 3.7 хувь, хромын агууламж 2.8 хувь, стронцийн агууламж 6.1 хувиар тус тус зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан. Хяналт шинжилгээний бүх цэгт мөнгөн усны агууламж илрээгүй. Тухайлбал, хар тугалгын бохирдол Хан-Уул дүүргийн Яармагийн эцэс орчимд, цайрын бохирдол Чингэлтэй дүүргийн 17 дугаар сургууль орчим, Баянгол дүүргийн 28 дугаар сургууль орчим, Сүхбаатар дүүргийн 29 дүгээр сургууль болон Засгийн газрын ордон орчмын бүс, Сонгинохайрхан дүүргийн Геологийн төв лаборатори болон Баянхошуу орчим, Баянзүрх дүүргийн Кино үйлдвэр, Жуковын музей орчимд тус тус өндөр агууламжтай илэрсэн.</p>		
15	Арга хэмжээ 2. QGIS программ ашиглан Улаанбаатар хотын сар бүрийн агаарын бохирдлын тархалтын зураглал хийх /SO ₂ , NO ₂ , PM ₁₀ , PM _{2.5} /	Агаарын бохирдлын тархалтын зураг	12	Эхний 6 сарын агаарын бохирдлын тархалтын зураг гарсан байна	Улаанбаатар хотын 2026 оны 1, 2, 3, 4, 5 дугаар сарын хүхэрлэг хий /SO ₂ /, азотын давхар исэл /NO ₂ /, PM ₁₀ тоосонцор, PM _{2.5} тоосонцрын дундаж агууламжийг QGIS программ ашиглан ялгарлын агууламжийн тархалтын	1-6 сар	100%

					<p>хэмжээг цэг тус бүрээр тооцоолж, нийт 20 ширхэг зураг гаргасан.</p> <p>Мөн 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар агаарын чанарын хяналт шинжилгээний автомат станцын цэг тус бүрээр хоногийн дунд агууламжийг MNS 4585:2025 "Агаарын чанарын стандарт"-тай харьцуулахад хүхэрлэг хий 211, азотын давхар исэл 553, PM10 тоосонцор 445, PM2.5 тоосонцор 664, нүүрстөрөгчийн дутуу исэл 125, озон 107 удаа тус тус давсан байна. Хүхэрлэг хийн хамгийн өндөр агууламж 2026 оны 01 дүгээр сарын 22-нд Баянхошуу орчим 271 мкг/м³, азотын давхар ислийн хамгийн өндөр агууламж 02 дугаар сарын 01-нд Налайх орчим 109 мкг/м³, PM10 тоосонцрын хамгийн өндөр агууламж 02 дугаар сарын 26-нд Цахилгаан станц орчим 397 мкг/м³, PM2.5 тоосонцрын хамгийн өндөр агууламж 01 дүгээр сарын 24-нд Баянхошуу орчим 386 мкг/м³ тус тус хүрсэн байна.</p> <p>2026 оны 06 дугаар сарын зураг 07 дугаар сард гарна.</p>		
Гүйцэтгэлийн зорилт 4. Ус, цаг агаар, орчны бүх төрлийн мэдээ, мэдээлэл, аюулт болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний хүртээмжийг нэмэгдүүлэх							
16	Арга хэжээ 1. Салбарын хэмжээнд Хот, суурины 5 хоногийн мэдээний чанарыг сайжруулах;	Урьдчилсан мэдээний таарц, хувь	88.1 хувь байсан /сүүлийн 3-н жилийн дундаж/	Салбарын хэмжээнд дунджаар 88.7 хувь хүргэж, 5 хоногийн мэдээний чанарыг ахиулна.	Урьдчилан мэдээлэх салбарын хэмжээнд хот, суурины 5 хоногийн урьдчилсан мэдээний таарцын эхний хагас жилийн дундаж 89.6 хувь, хүрэх түвшинг 0.9 хувиар давуулан биелүүлсэн.	1-6 сар	100%
17	Арга хэжээ 2. Хуурайшлын зэргийн мэдээллээр хуульд заасан хугацаанд БОУАӨЯ, ОБЕГ зэрэг холбогдох байгууллага,	Үйлчилсэн хоногийн тоо	Хуулийн хугацаа 140 хоног байдаг	Хавар 3 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 20-н буюу 90 хоног мэдээг гаргаж түгээнэ	Хуурайшлын зэргийн мэдээллийг 2026 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөс БОУАӨЯ, ОБЕГ зэрэг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд нийт 71 удаа шуурхай хүргэж ажилласан.	1-6 сар	100%

	мэргэжилтнүүдэд шуурхай үйлчлэх						
18	Арга хэмжээ 3. Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний чанарыг сайжруулах	СМ, УСМ-ний онч, хувь	84.7% /сүүлийн 3-н жилийн дундаж/	84.7% -аас доошгүй байх	Ус, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед Сэрэмжлүүлэх мэдээ болон Урьдчилан сэргийлэх мэдээний онч эхний хагас жилийн дунджаар 93.9 хувьд хүрсэн.	1-6 сар	100%
19	Арга хэмжээ 4. Нислэгт зориулсан цаг агаарын мэдээний чанарыг сайжруулах	Нислэгт зориулсан урьдчилсан мэдээний таарц, хувь	Урьдчилсан мэдээний дундаж таарц 80.0 хувиас доошгүй /хүлцэж болох хязгаарлалт/	Урьдчилсан мэдээний таарцыг хүлцэж болох хязгаарлалтаас бууруулахгүй байх, цаг агаарын урьдчилсан мэдээ гаргахад нам болон дунд өндрийн цаг агаарын зургийг орон зай, цаг хугацааны өндөр нарийвчлалтай тоон загварын үр дүнг гаргаж ашиглах	Буянт-Ухаа ОУНБ-ын 9 цагийн урьдчилсан мэдээний дундаж таарц 96.39%, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 95.06%. Чингис хаан ОУНБ-ын 9 цагийн урьдчилсан мэдээний дундаж таарц 94.5%, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 92.78%. Буянт-Ухаа болон Чингис Хаан ОУНБ орчимд нам өндрийн салхины шилжлэгийг тооцоолж, сэрэмжлүүлэх мэдээ гаргах тоон загварын үр дүнг боловсруулж, хагас жилийн байдлаар 23 удаа сэрэмжлүүлэг мэдээ гарган нислэгийн аюулгүй байдлыг ханган ажилласан. Суперкомпьютерт суурилсан Цаг агаарын тоон загвараар Монгол орны хэмжээгээр 5км, төвийн бүс нутгаар 3км, Улаанбаатар хот орчмоор 600м нарийвчлалтай үр дүнг гаргаж нислэгт зориулсан цаг агаарын урьдчилсан мэдээнд ашиглаж байна.	1-6 сар	100%
20		Нислэгт зориулж дамжуулсан ажиглалтын мэдээний тоо, хувь	Ажиглалтын мэдээний дамжуулалт 95 хувиас доошгүй	Бодит ажиглалтын мэдээний чанар 95%-аас доошгүй байх, Буянт-Ухаа, Чингис Хаан олон улсын нисэх буудлын зурвас дээр байрлаж буй,	Чингис хаан ОУНБ-ын цаг агаарын бодит ажиглалтын мэдээг 30 минут тутамд 8861 мэдээ, Буянт-Ухаа ОУНБ-ын цаг агаарын бодит ажиглалтын мэдээг 1 цаг тутамд 4368 мэдээ, SPECI мэдээг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхцөл бүрдсэн цаг тухай бүрд нь хийн, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс	1-6 сар	100%

				<p>цаг уурын автомат станц, алсын барааны тэмдэгт зэрэг багаж төхөөрөмжинд тогтсон цаг хугацаанд үйлчилгээ хийх</p>	<p>болон бусад хэрэглэгч байгууллагуудад үйлчилж, шаардлагатай нөхцөлд нэмэлт мэдээллээр ханган нислэгийн саатал, зөрчилгүй ажилласан. Бодит ажиглалтын мэдээний чанар 99.8% байна.</p> <p>Сар бүрийн 15, 25-нд Чингис хаан ОУНБ-д MAWS-301 болон AWS-330, Буянт-Ухаа ОУНБ-д MILOS-520 болон AWS-310 цаг уурын автомат станцуудын тоололтоор харьцуулсан ажиглалт хийхэд тоололтууд зөвшөөрөгдөх хэмжээнд байсан.</p> <p>Нисэх буудлын зурвас дээр байрлаж буй, цаг уурын автомат станц, алсын барааны тэмдэгт зэрэг багаж төхөөрөмжинд хуваарийн дагуу үйлчилгээ хийсэн. Чингис хаан, Буянт-Ухаа ОУНБ-уудын хөөрч, буух зурвасын дагуух шөнийн гэрлэн тэмдэгтүүд болон Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын үйлчилгээний хэсэгт ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянаж, гэмтэл доголдол гарсан тухай бүр холбогдох албан хаагчдад мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авч, хэвийн ажиллагааг ханган ажилласан.</p> <p>Мөн 2026 оны 01-р сарын 14-нд VAISALA-310 автомат станцын, 01-р сарын 14, 20-нд AWS-310 станцын цагийг тохируулсан бөгөөд 03-р сарын 13-нд MILOS-520 автомат станцын RVR -н заалтын утгыг P-2000 болгон өөрчилж, Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа байгууллага Нисэхийн холбоо навигаци ажиглалтын албанаас холбогдох инженер тохиргоо хийсэн.</p> <p>Иргэний нисэхийн үндэсний төвийн Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн Радио, цаг уур, цахилгаан цулын</p>	
--	--	--	--	---	--	--

					инженер, Улсын байцаагч Б.Бямбадорж Чингис хаан ОУНБ-ын Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын мэдээний үйлчилгээнд ашиглагдаж буй MAWS-301 цаг уурын автомат станцад 2026 оны 03 дугаар сарын 25 болон 04-р сарын 09-ний өдрүүдэд шалгалтын хэмжилт хийж, баталгаажуулсан.		
21	Арга хэмжээ 5. Олон улсын төвүүдийн тоон загваруудын үр дүнг татан авч, зураглах, шуурхай үйл ажиллагаанд ашиглах	Загваруудын ирц, хувь	Дэлхийн загваруудын ирц 99%	Дэлхийн хэмжээний ECMWF, NCEP-GFS, GSM-JMA загваруудын үр дүнг авч, зураглах, ирцийг 99.5%-д хүргэсэн байна.	Эхний хагас жилийн байдлаар ECMWF загварын ирц 99.3%, NCEP_GFS загварын ирц 99.7%, JMA_GSM загварын ирц 99.5% байна. ECMWF-ийн 1, NCEP_GFS-ийн 1, JMA_GSM-ийн 3-н хугацаа тус тус мэдээ цахилгаан тасарсны улмаас дутуу болон татагдаагүй, мэдээний серверт алдаа гарсан. Шуурхай үйл ажиллагааг ханган, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, дутуу орсон мэдээг дахин татах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	1-6 сар	100%
22	Арга хэмжээ 6. Цаг агаарын тоон загваруудын бодолтын хэвийн ажиллагааг хангаж ажиллах	Загваруудын бодолтын хувь	Бүс нутгийн загваруудын бодолтын хувь 96%	Бүс нутгийн түвшинд богино дунд хугацааны урьдчилсан мэдээ гаргах шуурхай үйл ажиллагааг ханган ажиллаж, WRF, MM5 загваруудын бодолтын хувийг 96.5%-д хүргэнэ.	Бүс нутгийн түвшинд 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шуурхай үйл ажиллагаанд нэвтэрсэн WRF/KIM/ загвар 122 удаа бодолт хийхээс 120 удаа бодогдож, 2 бодолт цахилгаан тасарсны улмаас хийгдээгүй, бодолтын хувь 98.36%. WRF GFS загвар 301 удаа бодолт хийхээс 296 удаа бодогдож, 5 бодолт цахилгаан тасарсны улмаас хийгдээгүй, бодолтын хувь 98.3%. UM(N768 мэдээ) загвар 192 удаа бодолт хийхээс 189 удаа бодогдож, 3 бодолт цахилгаан тасарсны улмаас хийгдээгүй, бодолтын хувь 98.4%. UM(N512 мэдээ) загвар 100 удаа бодолт хийхээс 100 удаа бодогдсон бөгөөд тус мэдээ 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр зогссон.	1-6 сар	100%

					<p>Шуурхай үйлчилгээнд ашиглагдаж байсан GUM загварыг БНСУ-ын Цаг уурын газар 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр зогсоохтой холбогдуулан дараагийн үеийн KIM загварын үр дүнг анхны болон захын нөхцөлөөр ашиглан шуурхай үйлчилгээний загваруудыг шилжүүлэх шаардлага үүсэж, WRF-KIM загварыг тохируулах, нэвтрүүлэх ажил системийн түвшинд хийгдсэн. ЦУОШГ-ын даргаас БНСУ-ын Цаг уурын газрын даргад KIM загварын өмнөх хугацааны өгөгдлийг авах хүсэлтийг хүргүүлсэн. Шаардлагатай үед хяналт тавьж, мэдээг нөхөх, бодолт нөхөж бодуулах зэргээр ажиллаж байна.</p> <p>Мөн суперкомпьютерийн багтаамжийг хянаж, суллах, тоон загваруудын мэдээллийн сан болох SQL-г backup хийх ажил тогтмол хийгдэж байна.</p>		
23	Арга хэмжээ 7. Сар, улирлын урьдчилсан төлөвийн таарцыг сайжруулж, олон нийтэд хүргэх	Сар, улирлын урьдчилсан мэдээний таарц/ Мэдээний тоо	61.5/ 58%/ 12 удаа	Сар бүр улсын хэмжээнд боловсруулж, таарцыг 61.7% /58.2%-д хүргэнэ.	<p>Сарын урьдчилсан төлөвийн таарцыг 137 станцаар дүгнэж, дүнг нэгтгэсэн. Сарын урьдчилсан мэдээний дундаж таарц 63.4%:</p> <ul style="list-style-type: none"> - 12 сард гаргасан 1 сар 70.1 хувь (ТЕМ: 73.7%, ТУН: 66.4%) - 1 сард гаргасан 2 сар 52.3 хувь (ТЕМ: 41.8%, ТУН: 62.8%) - 2 сард гаргасан 3 сар 68.0 хувь (ТЕМ: 72.4%, ТУН: 63.5%) - 3 сард гаргасан 4 сар 69.5 хувь (ТЕМ: 83.0%, ТУН: 56.0%) <p>Улирлын урьдчилсан төлөвийн дундаж таарц:</p> <ul style="list-style-type: none"> - 9 сард гаргасан 11, 12, 1-р саруудын дундаж таарц 44.8% - 10 сард гаргасан 12, 1, 2-р сарын дундаж таарц 56.4% - 11 сард гаргасан 1, 2, 3-р сарын дундаж таарц 56.8% 	1-6 сар	100%

					<ul style="list-style-type: none"> - 12 сард гаргасан 2, 3, 4-р сарын дундаж таарц 51.0% - 1 сард гаргасан 3, 4, 5-р сарын дундаж таарц 65.7% - 2 сард гаргасан 4, 5-р сарын дундаж таарц 69.5% - 3 сард гаргасан 5-р сарын дундаж таарц 61.5% <p>ЦУОШГ-ын www.weather.gov.mn сайт болон мэдээлэл хүргэх өөрийн сувгуудаар сар болон улирлын урьдчилсан төлөвийг тухай бүрд (сарын төлөв, улирлын төлөв тус бүр 5 удаа) байршуулж, олон нийтэд үйлчилсэн. ЦУОШГ-ын мэдээллийн студид 5 удаа бичлэг хийлгэж, мэдээллээр үйлчилсэн.</p>		
24	Арга хэмжээ 8. "Азийн бүсийн уур амьсгалын мониторинг, үнэлгээ ба урьдчилсан төлөвийн 22 дугаар хурал", "Зүүн Азийн өвлийн улирлын төлөв хэлэлцүүлэх" 14 дүгээр бага хуралд оролцох	Илтгэл хэлэлцүүлэх	Монгол орны 2025 оны 5–8 дугаар сарын болон 2025-2026 оны өвлийн улирлын урьдчилсан төлөв гаргаж, илтгэл хэлэлцүүлсэн.	Азийн бүсийн уур амьсгалын мониторинг, үнэлгээ ба урьдчилсан төлөвийн 22 дугаар хуралд 2026 оны 5–8 дугаар сарын урьдчилсан төлөв гаргаж, илтгэл хэлэлцүүлнэ.	БНХАУ-ын Нанжин хотноо 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Азийн бүсийн уур амьсгалын мониторинг, үнэлгээ ба урьдчилсан төлөв" сэдэвт 22 дугаар хуралд оролцсон. Тус хуралд 2025-2026 оны өвлийн улирлын уур амьсгалын тойм болон орчил урсгалын онцлогийг илэрхийлсэн тойм бэлтгэж, 2026 оны зуны улирлын урьдчилсан төлөв гарган, илтгэл хэлэлцүүлсэн.	1-6 сар	100%
25	Арга хэмжээ 9. Суперкомпьютерын (HPE Cluster) бэлэн байдлыг хангах	Засвар үйлчилгээ хийсэн тоо	-	Суперкомпьютерын техникийн болон программ хангамжийн найдвартай, тогтвортой, тасралтгүй ажиллагааг 24/7 горимоор хангана	Суперкомпьютерын техникийн болон программ хангамжийн найдвартай, тогтвортой, тасралтгүй ажиллагааг 24/7 горимоор ханган ажилласан. Үүнд: Бүх compute/login/storage node ажиллаж байгаа эсэхийг шалгах, хүлээгдэж буй, ажиллаж буй статус шалгах, scheduler, OS, hardware log-д алдаа гарсан эсэхийг шалгах, хэрэглэгчийн асуудал шийдэх, түр диск зайг чөлөөлөх зэрэг ажлыг HPC cluster сервер дээр хийж гүйцэтгэсэн.	1-6 сар	100%

26	Арга хэмжээ 10. Шуурхай үйлчилгээний динамик загварын сайжруулалтыг хийх	Прогнозын урьдчилал	240 цаг	Шинэ суперкомпьютерын технологийг ашиглан WRF-UM загварыг өвөл болон зуны хувилбараар тохируулсан байна.	<p>Солонгосын GUM-N768 загварын мэдээлэл 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс зогссон тул WRFv4.7.1 загварын анхны болон захын нөхцөлийг KIM загварын өгөгдлөөр солих системийн шинэчлэлийг дараах байдлаар хийж гүйцэтгэв.</p> <ul style="list-style-type: none"> - Суперкомпьютерийн тохиргоо: БНСУ-ын Цаг уурын газраас ирсэн KIM загварын мэдээг шуурхай татах, хадгалах процессыг автоматжуулж, өгөгдлийг задлах боломжтой болгож, 2026 оны 01-03 дугаар сарын өгөгдлийг нөхөн бодуулав. - Прогнозын хугацаа сунгалт: Багц скриптийг шинэчлэн бэлтгэж, WRF-KIM загварын прогнозын хугацааг 264 цаг (11 хоног) болгов. Түүнчлэн SQL сервер (192.168.100.73) дээрх 10 хоногийн өгөгдлийн сангуудыг 11 хоногийн бүтэцтэй болгон өөрчилсөн. - Программ хангамжийн шинэчлэл: Загварын үндсэн элементүүд (температур, салхи, тунадас), тэдгээрийн засварласан утга, хамгийн их/бага агаарын температур болон тэдгээрт харгалзах алдаа таарцыг тооцоолох программ хангамжуудыг бүрэн шинэчилж, 11 хоногийн хугацаанд шилжүүлэв. <p>Прогнозын утгыг ансамбль хийж ашиглах, динамик загварыг сайжруулах ажлын хүрээнд дараах туршилтуудыг гүйцэтгэв.</p> <ul style="list-style-type: none"> - Өгөгдлийн шилжилт: GUM мэдээгээр WRF Soil nudging загварын тохируулгыг хийж байсан ч өгөгдлийн мэдээ зогссон тул KIM загварын мэдээлэл рүү шилжүүлсэн. - Нөхөн бодолт, туршилт: KIM өгөгдлийг ашиглан 2026 оны 01 дүгээр сарын 12- 	1-6 сар	100%
----	--	---------------------	---------	--	---	---------	------

					ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацааны бодолтыг нөхөн гүйцэтгэсэн. Бодолтуудын алдааг дүгнэн үзэхэд 1-3 дугаар саруудын KIM мэдээний хувьсагчдын зөрүүнээс алдаа ихтэй гарсан ба 4-р сарын бодолтын алдааг үнэлэн шуурхай үйлчилгээнд ажиллаж байгаа WRF-KIM загвартай харьцуулалтыг хийсэн.		
27	Арга хэмжээ 11. Голын урсац, усны түвшний богино хугацааны урьдчилсан мэдээ, хаврын шар усны үерийн зураглал гаргах	Урьдчилсан мэдээний таарц/ Зураглалын тоо	68%/ 69%/ 3 удаа	Голын урсац, усны түвшний богино хугацааны урьдчилсан мэдээний таарцыг 69%/ 70%-д хүргэж, шар усны үерийн аюулын зураглал 3 удаа гаргана.	Ус судлалын 20 гол-харуулаар усны түвшний богино хугацааны прогнозыг 4, 5 дугаар саруудад өдөр бүр гарган хэрэглэгчдэд үйлчлэв. Урьдчилсан мэдээний таарц 68.3%. Хаврын шар усны үерийн аюулын зураглалыг 2026 оны 02 дугаар сарын 20, 28-ны өдрүүд, 03 дугаар сарын 10, 20, 31-ний өдрүүдэд тус тус боловсруулан, нийт 5 удаа ЦУОШГ-ын вэб сайт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэглэгчдэд шуурхай үйлчилсэн. Мөн тухайн хугацаанд сэрэмжлүүлэг мэдээг хүргэн ажилласан.	1-6 сар	100%
28	Арга хэмжээ 12. ХААЦУ-ын тойм, зөвлөмж, урьдчилсан мэдээ боловсруулж үйлчлэх	Тойм/Зөвлөмж/ Мэдээний тоо	90/3/9	ХААЦУ-ын 46 тойм, 2 зөвлөмж, 4 урьдчилсан мэдээг боловсруулан, https://weather.gov.mn/ цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлнэ.	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд цаг агаарын нөхцөл хэрхэн нөлөөлсөн болон өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлын талаарх 10 хоног тоймыг 18 удаа, жил, улирлын тойм, үлийн цагаан оготны голомт, тархалтын зураглал (4 дүгээр сар), хөрсний чийг, мал аж ахуйн цаг уурын зэрэг 46 тойм мэдээг тус бүр төлөвлөгөөт хугацаанд боловсруулан https://weather.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мал төллөх үеийн цаг агаарын нөхцөлийн зөвлөмж, хөрсний угтвар чийгийн мэдээг боловсруулж, тариа тариалах үеийн агро зөвлөмж зэрэг 2 зөвлөмжийг гаргасан.	1-6 сар	100%

29	Арга хэмжээ 13. Байгаль цаг агаарын гамшигт үзэгдэл зудаас сэрэмжлүүлэх мэдээллийг боловсруулан хэрэглэгчдэд үйлчлэх	бэлчээрийн даац багтаамж/зудын урьдчилсан төлөв/зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ	1/3/3 удаа	2025-2026 оны зудын урьдчилсан төлөв, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг тус бүр 1 удаа боловсруулан www.weather.gov.mn цахим хуудсанд байршуулан олон нийтэд үйлчилсэн байна.	Зудын урьдчилсан төлөвийг 4 удаа, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2 удаа боловсруулан цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод хүргэсэн. ОБЕГ болон ХХААХҮЯ-нд зудтай болон зудархуу сумдын жагсаалт, бусад мэдээллийг тусгайлан хүргэж ажилласан. НҮБ-ын Хүмүүнлэгийн багийн хуралд зуд, мал өвөлжилтийн цаг агаарын нөхцөлийн талаар 3 удаа илтгэл хэлэлцүүлж, мэдээлэл хүргэн ажилласан.	1-6 сар	100%
30	Арга хэмжээ 14. Цөлжилт газрын доройтлын төлөв байдлын нэгдсэн болон сэдэвчилсэн зураглал хийх	Цөлжилт газрын доройтлын зураглал	Цөлжилт атласыг 2021 онд боловсруулсан.	Цөлжилтийн атласын сэдэвчилсэн зураглалуудыг боловсруулна.	Цөлжилтийн үнэлгээг хийх аргазүйн талаар үе шаттай хэлэлцүүлэг явуулж, цөлжилтийн үнэлгээний үндсэн болон сэдэвчилсэн зураглал, үр дүнг гарган ажиллаж байна.	1-6 сар	50%
31	Арга хэмжээ 15. Уур амьсгалын сар, жилийн тойм мэдээгээр үйлчлэх	Сар, жилийн тойм мэдээний тоо	12/ 1 удаа	Уур амьсгалын сар, жилийн тойм мэдээг 6/ 1 удаа боловсруулна.	2025 оны уур амьсгалын жилийн эмхтгэлийг 137 өртөө, 70 гаруй элементүүдээр гаргаж, жил, улирлын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны олон жилийн дунджаас хазайх хазайлт, экстремаль утгуудаар тархалтын зураг, график үйлдэж, 2025 оны уур амьсгалын тоймын бичиглэлийг хийж, вэб сайтад байршуулсан. Олон улсын бүсийн төвд 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр илгээсэн. Нийт 137 өртөөний 2025 оны 12-р сар, 2026 оны 1-5 дугаар сарын тайланг хүлээн авч, тухайн саруудын эмхтгэлийг боловсруулан, сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны олон жилийн дунджаас хазайх хазайлтын тархалт болон хоногийн явц, тухайн сард ажиглагдсан үнэмлэхүй их, бага утга, 30 градус цельсээс хүйтэн өдрийн тоогоор 6 удаа тойм бичиж,	1-6 сар	100%

					төлөвлөгөөт хугацаанд вэб сайтад байршуулсан.		
32	Арга хэмжээ 16. Байгаль орчны мэдээллийн санг мэдээллээр баяжуулж, нэмэлт модулиуд хөгжүүлэх, өдөр тутмын шуурхай ажиллагааг хангах	Хөгжүүлсэн программын тоо/ баяжуулсан мэдээний тоо	2025 онд 6 дэд санд хөгжүүлэлт, 20 дэд санд мэдээгээр баяжуулсан.	2-3 дэд санд программын хөгжүүлэлт хийгдсэн байна.	Байгаль орчны 23 суурь мэдээллийн сангийн 54 дэд сангийн шуурхай, хэвийн ажиллагааг ханган ажилласан. Нийт 18 мэдээллийн санд 63638 мэдээ бүрдүүлсэн. 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд мэдээ бүрдүүлэлт: - Эвдэрсэн газар – 124, - Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагаа – 4456, - Ус, рашаан – 5167, - Ойн нөөц – 291, - Агаарын бохирдол – 2, - Гадаад орчны цацрагийн түвшин - 32619, - Гамшиг/түймэр – 9414, - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ – 2402, - Байгаль орчны менежментийн төлөвлөгөө/тайлан - 5666, - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан - 269 - Байгаль орчны хүснэгтийн тайлан - 3412. Мөн 4 мэдээллийн санд програмын хөгжүүлэлт, шинэчлэлт болон газарзүйн мэдээний 2025, 2026 оны давхарга нэмэх хөгжүүлэлт хийсэн.	1-6 сар	100%
33	Арга хэмжээ 17. Хиймэл дагуулын мэдээг ашиглаж цасан бүрхүүл болон ой, хээрийн түймрийн зураглал боловсруулж үйлчлэх	Зургийн тоо	20/80	Цасан бүрхүүлийн зургийг 10ш, ой, хээрийн түймэр илэрсэн тохиолдол бүрд зураг тус тус боловсруулна.	Монгол орны цасан бүрхүүлийн зураглалыг 10 хоногийн давтамжтайгаар боловсруулж, Монгол орны хэмжээнд нийт 22 зураглал (Монгол хэлээр 11, англи хэлээр 11), 21 аймгийн хэмжээнд нийт 210 зураглал боловсруулсан, хиймэл дагуулын бүтээгдэхүүний www.icc.mn цахим хуудсанд байршуулсан.	1-6 сар	100%

					<p>Мөн Монгол орны болон 21 аймгийн цасан бүрхүүлийн эзлэх хувийг тооцоолж, график мэдээллийг нийт 11 удаа боловсруулан цахим хуудсанд нийтэлсэн.</p> <p>Монгол орны цасан бүрхүүлтэй болон цасгүй талбайг ангилан растер хэлбэрээр боловсруулж, Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтсээс гаргадаг цасны зузааны зурагт ашиглагдах растер мэдээг FTP хаягаар 8 удаа, Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсээс гаргадаг шар усны үерийн аюулын зураглалд ашиглах растер мэдээг 7 удаа тус тус байршуулсан.</p> <p>Ой, хээрийн түймэр 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр гарсан бөгөөд 5 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 7 аймгийн 18 суманд буюу Дорнод аймгийн Халхгол, Булган, Чойбалсан, Матад, Баянтүмэн, Чулуунхороот, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Баян-Адарга, Батширээт, Өмнөдэлгэр, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Түмэнцогт, Асгат, Ховд аймгийн Дөргөн, Төв аймгийн Мөнгөнморьт, Сэлэнгэ аймгийн Ерөө, Архангай аймгийн Ихтамир сумдын нутаг дэвсгэрт нийт 22 удаагийн ой, хээрийн түймэр бүртгэгдсэн бөгөөд давхардсан тоогоор 60 /Монгол хэлээр-30, Англи-30/ ширхэг зурган мэдээлэл бэлтгэн www.icc.mn цахим хуудсанд байршуулан Онцгой байдлын ерөнхий газар болон холбогдох байгууллагуудад тухай бүрт мэдээллэн ажилласан.</p> <p>Мөн 2026 онд Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймагт гарсан ой, хээрийн түймрийн шатсан талбайг 05 дугаар сарын 12-ны байдлаар зураглан, нийт 455063,52 га талбайг тооцоолов.</p>		
--	--	--	--	--	---	--	--

34	Арга хэмжээ 18. Дэлхийн цаг уурын байгууллагын мэдээллийн систем (WIS 2.0) суурилуулж турших	Туршилтын тоо	GISC JMA төвтэй өгөгдөл солилцох сувгийг тохируулах, бодит цагийн хуваарьт дамжуулалтыг хэрэгжүүлсэн.	Сервер компьютерт WIS 2.0 системийн программ хангамж суурилуулна.	Poweredge R740 серверт Ubuntu 24.04 LTS үйлдлийн систем болон WIS 2.0 системийг суулгаж, wis2box, wis2webapp үүсгэн Дэлхийн Цаг уурын байгууллага (WMO)-д бүртгэлтэй Монголын 139 станцуудын мэдээллийг wis2 мэдэгдэл дээр оруулан ажиллаж байна. WIS2 мэдэгдэл дээр татаж авах шинэ өгөгдлийн бэлэн байдлыг MQTT протоколыг ашиглан илгээж WIS2 мэдэгдлийн өгөгдлийг оруулан (public).public data татан авч судалсан. WIS2-ийн мэдэгдэл бүр нь өгөгдлийг HTTP (S) дээр татаж авах боломжийг олгохын тулд өгөгдлийн "каноник" URL-ийг оруулсан код нэмж өгсөн. Серверийг машин зааланд байршуулж, гадаад болон дотоод ip хаяг өгснөөр linux 24.04 ашиглаж болох anydesk суулган гаднаас хандах боломжтой болгосон.	1-6 сар	100%
Гүйцэтгэлийн зорилт 5. Төрийн төрөлжсөн архивын баримтын цаасан баримтын цахимжуулалтыг эрчимжүүлэх							
35	Арга хэмжээ 1. Төрийн архивын цаасан баримтыг бүрдүүлэлт хийх	Цаасан баримтын бүрдүүлэлт	2024 оны бүх цаасан баримтын бүрдүүлсэн.	2025 оны цаг агаарын болон хиймэл дагуулын мэдээ, зурган баримтын бүрдүүлэлт хийсэн байна.	2025 оны газар, өндрийн зургийн 21 хадгаламжийн нэгж хүлээн авсан. 488 ЦД-1 дэвтрийг хөмрөг үүсгэгч 4 байгууллагаас хүлээн авч, архивын 41 хадгаламжийн нэгжийг нөхөн бүрдүүлсэн.	1-6 сар	100%
36	Арга хэмжээ 2. Ус цаг уур, орчны шинжилгээний тоон мэдээ /файл/-ний санд бүрдүүлэлт хийх, уур амьсгалын горимын мэдээллийн сан баяжилт хийх	Уур амьсгалын горимын шалгагдаж баталгаажсан мэдээлэл /ISX, TAB, RES/-ээр мэдээллийн сангуудад баяжилт хийх; хувь	2025 оны горимын мэдээний баяжилт хийсэн хувь 99.7% байсан байна.	2025 оны 11-н сараас 2026 оны 3 сар хүртэлх мэдээний баяжилт 49.0% -иас багагүй баяжилт хийсэн байна.	Цаг уурын ажиглалтын 138 өртөө, 180 харуулын 2025 оны 11 дүгээр сараас 2026 оны 03 дугаар сарыг дуусталх хугацааны шалгагдаж баталгаажсан ISX, RES, TAB мэдээ нийт 4734 файлыг хүлээн авсан. Дээрх хугацааны TAB мэдээг MS SQL-ийн өгөгдлийн санд задлан оруулж, 138 өртөөний 490704 мөр цаг тутмын мэдээ, 361136 мөр 8 хугацааны мэдээ, 45572 мөр хоногийн мэдээ, 26191 мөр	1-6 сар	100%

					<p>үзэгдлийн мэдээ, 180 харуулын 213904 мөр 4 хугацааны мэдээ, 53574 мөр хоногийн мэдээ, 23965 мөр үзэгдлийн мэдээ нэмж баяжилт хийсэн.</p> <p>Цаг уурын ажиглалтын 138 өртөөний 2025 оны 08 дугаар сараас 2026 оны 03 дугаар сарыг дуустал нийт 966 сарын RES мэдээг <u>CliWare 2.1</u> системд задлан оруулж, мэдээллийн санг тус тус баяжуулсан.</p>		
37		Төрөлжсөн сангийн мэдээний бүрдүүлэлт хийх; хувь	2025 оны төрөлжсөн сангийн бүрдүүлэлт хийсэн хувь 98.5% байсан байна.	2025 оны 12 сараас 2026 оны 4 сарын мэдээний баяжилтыг 49.5%-иас багагүй бүрдүүлэлтийг хийсэн байна.	<p>Гадаргын усны 19 булгийн харуул, газрын доорхи усны цооногийн 40 харуул, голын усны температурын 136 харуул, гол нуурын цас мөсний зузааны 154 харуул, голын усны өнгөрөлт, түвшиний 136 харуул, нуурын усны түвшин, цас мөсний зузааны 36 харуул, усны биологийн 98 харуулын 2023 оны 1-12 сарын өдөр тутмын ажиглалтын мэдээг нөхөн бүрдүүлсэн.</p> <p>Мөн 2025 оны 12 дугаар сараас 2026 оны 3 дугаар сарын аэрологийн ажиглалтын 4 станцын 1290 файл, орон нутгийн агаарын чанарын 24 харуулын 1 файл, цаг уурын 214 автомат станцын 57099 файл, нарны цацрагийн ажиглалтын 14 станцын 44 файл, шар шороон шуурганы 2 станцын 2 файл, цацраг идэвхжилтийн түвшний 35 цэгийн 1 файл, Улаанбаатар хотын агаарын чанарын 16 харуулын 4 файл, усны чанарын мэдээний 115 цэгийн 2 файл, хөдөө аж ахуйн цаг уурын 182 станц, харуулын 4 файл буюу нийт 58446 файл мэдээг хүлээн авч нөхөн бүрдүүлсэн. Мэдээний баяжилт 50%.</p>	1-6 сар	100%
38	Арга хэмжээ 3. Төрийн төрөлжсөн архивын хадгаламжийн сангийн улсын шалгалтад бэлтгэх	Шалгалтын бэлтгэл хангагдсан байдал; хувь	0%	Улсын шалгалтын бэлтгэл 50% хангагдсан байна	<p>Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг гарган, дараах ажлыг хийгээд байна. Үүнд:</p> <p>- 14637 хадгаламжийн нэгжийн данс бүртгэлийг хянаж, 955 хайрцагт</p>	1-6 сар	100%

					<p>хайрцаглан, хадгалалт хамгаалалтын стандартыг хангасан.</p> <ul style="list-style-type: none"> - Хөмрөг үүсгэгч байгууллагын судалгааг хийж, шинэчлэн баталсан. - Салбарын цаасан болон цахим баримтын хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг шинэчилж, баримтын төрлийг нэмэгдүүлсэн. - Тоон мэдээний баримтын хөмрөгийг нэмэгдүүлж, хөмрөгийг шинэчлэн баталсан. <p>https://archive.weather.gov.mn/</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэглэгчдэд үйлчилж байгаа цахим үйлчилгээний төрлийг 1936 оноос хойш өнөөг хүртэлх усны ажиглалтын өнгөрөлт, түвшний мэдээгээр нэмэгдүүлсэн. - Хэрэглэгчдэд үйлчилдэг цахим системд захиалгын цэс шинээр нэмж, загварт өөрчлөлт хийсэн. - Тоон мэдээний болон өгөгдлийн сангийн метадата бүрдүүлэх ажил үргэлжилж байна. - Хадгаламжийн өрөөг 1-ээр нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. - Архивын баримтад нэгдсэн тооллого хийх ажил үргэлжилж байна. - Архивын Ерөнхий газраас зохион байгуулж байгаа төлбөртэй 3 сургалтад давхардсан тоогоор 4 албан хаагчийг, төлбөргүй сургалтад 1 албан хаагчийг хамруулсан. 	
<p align="center">Гүйцэтгэлийн зорилт 6. Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн мөрөөр хийгдэх ажлын төлөвлөгөөг батлуулж алдаа дудагдалыг арилгах арга хэмжээ авах</p>						

39	Арга хэмжээ 1. Монгол хэлний тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 165 дугаар тогтоол, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоол, зөвлөмжийн хүрээнд 2025 оны захирамжлалын баримт бичгийг хос бичгээр нөхөж боловсруулан стандартын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивд хадгалах ажлыг гүйцэтгэх	Захирамжлалын баримт бичгийг хос бичгээр боловсруулсан хадгаламжийн нэгжийн тоо	-	-	Хугацаа болоогүй.	7-12 сар	Үнэлэх боломжгүй
----	--	---	---	---	-------------------	----------	------------------

Гүйцэтгэлийн зорилт 7. Цаг уур, орчны шинжилгээний газрын төрийн захиргааны хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах

40	Арга хэмжээ 1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үйл ажиллагааны хэлэлцүүлэгт оролцох, санал гаргах	Хуулийн төсөл хэлэлцүүлэгт оролцсон тоо	-	Хуулийн төсөл хэлэлцүүлэгт оролцсон байна.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хувилбарыг 2025 оны 12 дугаар сард боловсруулж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагууд болон хүрээлэнгүүд, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоог ханган танхимын болон цахим хэлэлцүүлэг, ярилцлага, мэдээллийг хийсэн. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Үзэл баримтлал нь 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан. Нийт 10 гаруй удаагийн хэлэлцүүлэг, ярилцлагын үеэр гарсан саналуудыг авч тусган, хуулийн төслийг дахин боловсронгуй болгосон бөгөөд Засгийн газрын хуралдаанд оруулахаар төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авах ажлыг эхлүүсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн бүрдэл 5 багц ажлыг хийж дууссан ба эхний хагас жилд	1-6 сар	100%
----	--	---	---	--	---	---------	------

					Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. Яамдаас санал авахаар хүргүүлсэн.		
41	Арга хэмжээ 2. Салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх	Холбогдох журам шинэчлэгдэн, мөрдөгдөж эхэлсэн байна.	-	Холбогдох журам шинэчлэгдсэн байна.	Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт 1999 оноос хойш мөрдөгдөж ирсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг цаг үеийн хэрэгцээ шаардлага, технологи, аргазүйн шинэчлэлд нийцүүлэн боловсруулж, төслийг 2026 оны 02 дугаар сарын 10–25-ны өдрүүдэд байгууллагын цахим хуудас www.weather.gov.mn -д нийтэд нээлттэй байршуулан, санал авах ажлыг зохион байгуулсан бөгөөд 13 байгууллагаас ирүүлсэн саналыг хэлэлцэж, тусган ажилласан. Уг шинэчилсэн дүрэм, зааврыг “Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, заавар” батлах тухай ЦУОШГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/43 тоот тушаалаар баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж эхэлсэн. Шинэчлэн баталсан дүрэм, заавар нь нийт 13 бүлэгтэй ба дараах нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд: - Доплерийн радарын станц, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа, нислэгийн цаг уурын үйлчилгээ, мөс, мөстөлтэй гол дээр ажиллах үеийн болон цаг уурын автомат станцтай ажиллах аюулгүй ажиллагааны аюулгүй байдлын зохицуулалтыг тус тус нэмж тусгасан. - Мэдээлэл, холбооны сүлжээний бүлгийг шинэ технологид нийцүүлэн шинэчлэхийн зэрэгцээ ослын үеийн анхны тусламжийн заавар, ажлын	1-6 сар	100%

					<p>тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн журмыг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2021 оны 1 дүгээр тогтоол"-ын дагуу стандартын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн.</p> <p>https://namem.gov.mn/uploads/content/43.pdf</p>		
42	<p>Арга хэмжээ 3. ЦУОШГ-ын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах</p>	Хэрэгжилтийн хувь	100%	50%	<p>ЦУОШГ-аас 2026 онд 19 сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг боловсруулан, 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан бөгөөд төлөвлөгөөний дагуу "Тэсрэх бодис, тэсрэх материалтай харьцах ажилтан", "NAMIS программ дээр ажиллахад тулгарч буй хүндрэл, бэрхшээл", "Орчны шинжилгээний мэдээлэл үйлчилгээний чанарыг сайжруулах", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ойлголт, хэрэглээ", "2025 оны Шударга байдлын үнэлгээний танилцуулга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" зэрэг сэдвийн хүрээнд 9 сургалтыг танхим болон цахимаар амжилттай зохион байгуулсан байна. Мөн ЦУОШГ-ын Захиргааны хэлтсээс салбарын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, хууль эрх зүй, бодлого шийдвэр болон салбарын үйл ажиллагаатай холбоотой шинэ мэдээ, мэдээллийг цаг тухайд нь шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, байгууллагын дотоод уялдаа холбоо, ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор сар бүрийн 10-ны өдөр "Цахим сургалт, мэдээллийн цаг"-ийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Эхний хагас жилийн байдлаар 3 удаагийн "Цахим сургалт мэдээллийн</p>	1-6 сар	100%

					цаг"-ийг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор нийт 800 гаруй албан хаагч хамрагдсан.		
43	Арга хэмжээ 4. ЦУОШГ-ын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах	Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын тоо	2022 онд төрийн захиргааны 28 албан тушаалын албан тодорхойлолт батлуулсан.	29	2026 оны эхний хагас жилд Төрийн албаны зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 84, 85, 86 дугаар тогтоолоор төрийн захиргааны 33 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.	1-6 сар	100%
44	Арга хэмжээ 5. Цаг уур, орчны шинжилгээний газрын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн захиргааны байгууллагын хууль тогтоомж, хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг нэгтгэн гаргаж, биелэлтийн холбогдох байгууллагад тайлагнах	Тайлангийн тоо	7	Биелэлтийг нэгтгэж, тайланг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Засгийн газрын "Журам батлах тухай" 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан тайлагнах цаглаваруудад Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж, тайлагнаагүй болно. БОУАӨЯ-ны үйл ажиллагаанд хамаарах төсөл, арга хэмжээний 2026 оны I улирлын биелэлт болон дараагийн хагас жилд хийх ажлын төлөвлөгөөг загварын дагуу гаргаж 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус яамны Бодлого төлөвлөлтийн газарт цахимаар хүргүүлсэн.	1-6 сар	100%
45	Арга хэмжээ 6. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагчдад сургалт мэдээлэл өгөх	Сургалт мэдээллийн тоо	0	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагчдад мэдээлэл өгсөн байна.	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар М.Жамъянчойжилтай хамтран шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар салбарын нийт 525 албан хаагчдад цахим сургалт мэдээлэл өгсөн байна.	1-6 сар	100%

46	Арга хэмжээ 7. Цаг уур, орчны шинжилгээний газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангасан байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталсан байна.	Цаг уур, орчны шинжилгээний газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн байгаль орчны салбар хариуцсан ажилтан Э.Хүслэнгээс байгууллагын төлөвлөгөөнд оруулах нэмэлт саналуудыг 2026 оны 05 сарын 12-нд цахимаар ирүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөг байгууллагын сүүлийн хагас жилийн төлөвлөгөөнд нэмж тусгана.	1-6 сар	100%
----	--	-------------------	---	---	--	---------	------

Гүйцэтгэлийн зорилт 8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөлтийг салбарын хэмжээнд үнэлэн төсөв, хугацаа, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нөөцөд тулгуурлан төлөвлөж, 2027 улсын оны хөгжлийн төлөвлөгөө болон яамны жилийн төлөвлөгөөнд саналаа хүргүүлж, хэрэгжилтийг хангах, төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, гүйцэтгэлийн хяналтыг тавих

47	Арга хэмжээ 1. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий пассив өртөөний барилга ашиглалтад оруулах	Цаг уур, орчны шинжилгээний салбарт ногоон барилгын шийдлийг тусган баригдсан барилга, тоо	2	Баригдаж байгаа барилгуудыг ногоон барилгын шаардлагад нийцүүлэх зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.	БОУАӨЯ-ны захиалгаар 2025 онд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий "Очиртааб" ХХК-иар ногоон барилгын холбогдох шаардлагад нийцсэн нэг маягын зураг төсөв хийлгэсэн. Эхний хагас жилийн байдлаар батлагдсан өртөө, харуулын зураг төсөв бүгд холболтын зураг хийлгэж байгаа бөгөөд Зохиогчийн хяналтыг тус компани өөрөө хариуцан ажиллаж байна.	1-6 сар	50%
48	Арга хэмжээ 2. Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв болон бусад аймгийн 7 сумын цаг уурын өртөөний барилга, 17 сумын цаг уурын харуулын барилгыг шинээр ашиглалтад оруулах	Шинээр ашиглалтад оруулсан барилгын тоо	2	11 харуулын байр барих худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.	Өвөрхангай аймгийн УЦУОШТ-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Ариунбилгүүн" ХХК шалгарч, ажил гүйцэтгэж байгаа бөгөөд 2026 оны 06-р сарын 04-ний өдрийн байдлаар барилгын ажил 80% гүйцэтгэлтэй байна. Баянхонгор аймгийн УЦУОШТөвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр 2024 онд "Жэй энд Пи Жи" ХХК шалгарч, зоорьтой 3 давхар барилгын гадна өрлөг болон цонх, гадна шилэн карказны суурь 50%-ийг гүйцэтгэж, 2025 онд 769.7 сая төгрөг улсын төсөвт	1-6 сар	50%

					<p>батлагдсанаар барилгын 2 дахь шатны ажил 60-66% гүйцэтгэлтэй байна. Өмнөговь аймгийн УЦУОШТ-ийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Тост говь" ХХК шалгарч, 2025 оны 04 дүгээр сараас барилгын ажил эхэлсэн бөгөөд 2026 оны эхний хагас жилийн байдлаар 95% гүйцэтгэлтэй байна.</p> <p>Ус, цаг уурын харуулын байрны барилгын ажил нийт 11 байршилд хэрэгжиж байгаа бөгөөд Баян-Өлгий аймаг дахь харуулын байрны барилгын ажлын гүйцэтгэгчээр "Туранбилд" ХХК, бусад байршлын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Хос Ерөөл" ХХК тус тус шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Мөн захиалагчийн хяналтын ажлыг хэрэгжүүлэхээр Барилгын хөгжлийн төвтэй гэрээ байгуулсан боловч зарим байршлын зураг төсөв бүрэн бэлэн болоогүй, инженерийн шугам сүлжээний холболтын зураг төслийг боловсруулах ажил үргэлжилж байгаа тул барилгын ажлын явц төлөвлөсөн хугацаанаас бага зэрэг удаашрах төлөвтэй байна.</p>		
49	Арга хэмжээ 3. Төв байрны эрчим хүчний байнгын тасралтгүй үйл ажиллагааг хангах цахилгааны нөөц дизель станц 220кв хүчин чадал бүхий цахилгаан станц авч суурилуулах	Цахилгаан нөөц дизель станц /Улаанбаатар/	Хуучин станц 20 жил ашиглагдсан, хүчин чадал дутагдалтай	Гэрээ байгуулна.	ЦУОШГ-ын төв байранд нөөц дизель генератор худалдан авч суурилуулах арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, БОУАӨЯ/20260102011 дугаартай бараа худалдан авах цахим тендер зарласан. Гүйцэтгэгчээр "Барловорлд" ХХК шалгаран, 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр ажил гүйцэтгэх УТ2601300942002 дугаартай гэрээг байгуулснаар нөөц дизель генератор 220кв хүчин чадал бүхий цахилгаан станц худалдан авч суурилуулсан.	1-6 сар	100%

50	<p>Арга хэмжээ 4. Салбарын хэмжээнд төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх</p>	<p>Зарцуулалтыг хянасан байна.</p>	<p>2025 онд Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг ажилдаа хэрэгжүүлж хасагдсан зардлыг хэмнэгдэж байгаа зардлаас нь зохицуулалт хийж ажилласан.</p>	<p>2026 оны эхний хагас жилд байгууллагын өмч хөрөнгө болон батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.</p>	<p>ТӨБЗГ-ын www.umch.gov.mn шинэ системд 2025 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийг шивж оруулсан. Төрийн өмчийн хөрөнгийн программ шилжилтийг журмын дагуу явуулж, салбарын 2025 оны Төрийн өмчийн гэрээг 2026 оны 06 дугаар сард дүгнүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. Мөн 2026 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг хийж, шинэ QR кодыг Төрийн өмчийн программаас хэвлэж коджуулсан. Батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулж, зориулалтын дагуу зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна.</p>	1-6 сар	100%
51	<p>Арга хэмжээ 5. Цаг уур, орчны шинжилгээний салбарын хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих</p>	<p>Төсвийн болон хөрөнгө оруулалтын саналыг хуульд заасан хугацаанд, холбогдох журмын дагуу хүргүүлсэн байдал, хэрэгжилтийн хувь.</p>	<p>Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт тусгуулах саналыг хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд боловсруулан хүргүүлж, батлагдсан төсвийн зарцуулалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p>	<p>Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт тусгуулах саналыг хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд боловсруулан хүргүүлж, батлагдсан төсвийн зарцуулалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.</p>	<p>Цаг уур, орчны шинжилгээний салбарын хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, холбогдох тооцооллыг хийн, төсвийн төслийг боловсруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн төсөлд тусгуулахаар саналыг БОУАӨЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/382 дугаар албан бичгээр болон ERP цахим системээр хүргүүлсэн. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны эрсдэлийн мэдээллийг орон даяар тасралтгүй цуглуулах, боловсруулж хүргэхтэй холбоотой хээрийн ажиглалт, тээвэр, мэдээ дамжуулалт, мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах урсгал зардлуудыг тооцон тусгасан бөгөөд хөрөнгө оруулалтын төслийг барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, зураг төсөв гэсэн ангиллаар боловсруулсан.</p>	1-6 сар	100%

				<p>ЦУОШГ болон харьяа байгууллагуудын 2027 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор бүртгэн хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Одоогийн байдлаар холбогдох шалгуур шаардлагыг хангасан нийт 48 төсөл, арга хэмжээний саналыг тус системд бүртгэн оруулаад байна.</p>			
52	<p>Арга хэмжээ 6. Цаг уур, орчны шинжилгээний салбараас Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт оруулах саналыг боловсруулж, харьяалагдах дээд шатны байгууллагад хүргүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж хяналт тавих.</p>	<p>Санал боловсруулах, нэгтгэх, хугацаанд нь хүргүүлэх.</p>	<p>Саналыг хуульд заасан хугацаанд 100 хувь хүргүүлж, дээд шатны байгууллагад хамгаалсан, батлагдсан төсвийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж ажилласан</p>	<p>Саналыг хамгаалж, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих.</p>	<p>Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт тусгуулах саналын тооцооллыг хийж, 2027 оны төсвийн төсөлд Цаг уур, орчны шинжилгээний салбарын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор 2 шинэ хөтөлбөр зориулалтыг ангиллаар нэмж тусгуулах саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Мөн салбарын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн төсөвт өртөг, хэрэгжүүлэх үндэслэл, үр өгөөж, хүрэх үр дүнг нарийвчлан тусгаж, шаардлагатай тоон болон чанарын мэдээллээр хангасан бөгөөд салбарын хэмжээнд үүссэн байр ашиглалтын зардал, цалингийн сангийн дутагдлыг нарийвчлан тооцож, нэмэлт санхүүжилтийн шаардлагыг үндэслэлтэйгээр боловсруулан хамгаалсан.</p> <p>Мөн 2025 онд гэнэт ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжийн зардлын тооцооллыг гаргаж, 2026 оны төсөвт тусгуулах</p>	1-6 сар	100%

					асуудлыг холбогдох шатанд амжилттай танилцуулж, хамгаалсан.		
53	Арга хэмжээ 7. Салбарын болон агентлагийн үйл ажиллагааг зохицуулж, батлагдсан төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавих ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг хангаж, төсвийн гүйцэтгэлийн явцад хяналт тавих	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу 100 хувь үр ашигтай зарцуулж, салбар, агентлагийн үйл ажиллагааны уялдаа, хяналтыг бүрэн хангасан.	Төсвийн зарцуулалтын үр ашигт үнэлгээ хийж, зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Батлагдсан төсвийн үр ашигтай зарцуулалтад хяналт тавих үүргийн хүрээнд харьяа байгууллагуудын 2025 оны өр төлбөрийг тухайн байгууллагын давсан орлогоос санхүүжүүлэн барагдуулах чиглэлийг 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 04/166 дугаар албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласны үр дүнд салбарын хэмжээнд 2025 онд үүссэн хуримтлагдсан өр төлбөрийг бүрэн барагдуулж, өргүй болсон.	1-6 сар	100%
54	Арга хэмжээ 8. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарыг хамарсан байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маяг, хандлагын талаар олон талт нөлөөллийн ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах	Танилцуулах хэлбэр	-	Нөлөөллийн ажлын талаар салбарын хэмжээнд танилцуулсан байна.	Арга хэмжээний хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо (ESG)-г хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд ЦУОШГ-ын даргын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо (ESG)-г хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)-ын зарчмыг олон улсын түвшинд амжилттай хэрэгжүүлж буй БНСУ-ын Байгаль орчны корпорацитай хамтран холбогдох туршлага, ноу-хауг хуваалцах, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор тус улсад салбарын удирдах албан тушаалтнууд сургалтад хамрагдсан. Мөн Монгол Улсын ЦУОШГ-т 2026 оны 04 дүгээр сарын 22, 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд салбарын албан хаагчдад зориулсан туршлага хуваалцах сургалтыг зохион байгуулсан.	1-6 сар	100%

Гүйцэтгэлийн зорилт 9 Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, агентлагийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

55	Арга хэмжээ 1. Цаг уур, орчны шинжилгээний газар, харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Тайлан, зөвлөмжийн тоо	Тайлан, зөвлөмжийн тоо 2	Хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргана. Тайланг БОУАӨЯ-нд хүргүүлж, ил тод байдлыг хангасан байна.	Харьяа 25 байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн зөвлөмжийг 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр цахимаар хүргүүлэн, мэдээлэл өгч, агентлагийн тайлангийн ил тод байдлыг ханган https://namem.gov.mn/p/activity-report цахим хуудсанд байршуулсан. Цаг уур, орчны шинжилгээний газрын эхний хагас жилийн тайланг БОУАӨЯ-нд 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/450 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар нийт 75 арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай байна. Харьяа 25 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар нэгтгэн авсан бөгөөд тайлангийн явцын хяналт шинжилгээг хийж 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор үнэлгээг баталгаажуулна.	1-6 сар	100%
56	Арга хэмжээ 2. Бодлогын баримт бичиг болох Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх	Танилцуулга, зөвлөмжийн тоо	Тайлангийн тоо 1	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж танилцуулга гаргана.	Хугацаа болоогүй.	1-6 сар	Үнэлэх боломжгүй

57	Арга хэмжээ 3. Агентлагийн болон харьяа байгууллагын албан хаагчтай холбоотой өргөдөл гомдолд дотоод хяналт шалгалт хийж, удирдлагад тайлагнах	Танилцуулгын тоо	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 45 хоног	Өргөдөл, гомдлын болон төлөвлөгөөт бус шалгалтын хугацааг 45 хоногоос 35 хоног болгон бууруулна.	Харьяа байгууллага, нэгжийн удирдлагын хууль бус үйлдэл, үйл ажиллагаатай холбоотой 4 өргөдөл гомдол, дээд шатны байгууллагад гаргасан 3 өргөдөл гомдол, Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд гаргасан 2 өргөдөл гомдлыг хүлээн авч, судлан холбогдох асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдаас тайлбар мэдээлэл авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн ажилласан. Иргэнээс ирсэн гомдлын дагуу харьяа байгууллагын 1 дарга дсануулах арга хэмжээний санал гарч, албажсан байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 30 хоног.	1-6 сар	100%
58	Арга хэмжээ 4. Мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	Хэрэгжилтийн хувь 80%	https://shilen.gov.mn -д оруулсан мэдээнд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж өгсөн байна. 90%-д хүргэнэ.	Цаг уур, орчны шинжилгээний салбарын 26 байгууллага "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн хэрэгжилтийн хүрээнд нээлттэй мэдээллийн www.shilen.gov.mn сайтад нийт 5 бүлэг, 87 нэр төрлийн мэдээ мэдээллээс өөрийн байгууллагад хамаарал бүхий мэдээ мэдээллийг ил тод, хүртээмжтэй, үнэн зөв, эх сурвалжийн найдвартай байдлыг ханган, хуулийн хугацаанд бүрэн оруулсан эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээг улирал бүр хийж танилцуулга бэлтгэсэн. 2025 оны 4 дүгээр улирал, 2026 оны 1 дүгээр улирлын үнэлгээг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг гарган, харьяа 25 байгууллагад 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 05/89, 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/400 тоот албан бичгээр болон 90%-аас доош үнэлгээтэй 12 байгууллагын удирдлагад 2026 оны 05 дугаар сарын	1-6 сар	100%

					<p>21-ний өдрийн 01/401 тоот албан бичгээр тус тус мэдэгдэл хүргүүлсэн. Мөн салбарын 26 байгууллагын 2025 оны жилийн эцсийн үнэлгээг нэгтгэн хяналт-шинжилгээ хийж, БОУАӨЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/67 тоот албан бичгээр хавсралт 122 хуудас бүхий ажлын цахим файлын хамт хүргүүлсэн. Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан "Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах талаар чиглэлийг харьяа 25 байгууллагад 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 05/210 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Тус хуулийн хэрэгжилтийг ханган www.shilen.gov.mn сайтад байршуулсан мэдээллийн 2026 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл 97%.</p>		
59	Арга хэмжээ 5. Агентлаг, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган тайлагнаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Дотоод аудит, зөвлөмж хүргүүлсэн тоо	Тайлангийн тоо 4	Нийт 2 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, тайлан, зөвлөмж хүргүүлсэн байна.	<ol style="list-style-type: none"> 1. ЦУОШГ-ын 2026 оны дотоод аудитын төлөвлөгөөг батлуулж, байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажилласан. https://namem.gov.mn/p/auditdotood 2. УЦУОСМХ-ийн 2024-2025 оны үйл ажиллагааны баримтад санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээг мөрдөн ажиллаж байгаа байдал, түүний хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэл ашиглалт, бараа материалын зарцуулалтын байдал 	1-6 сар	70%

					<p>зэрэгт санхүүгийн дотоод аудит хийж гүйцэтгэсэн.</p> <p>УЦУОСМХ-ийн санхүүгийн дотоод аудит шалгалтаар 19 асуудлын бүртгэлээр нийт 426 сая төгрөгийн алдаа, зөрчил гарсан зөвлөмжийг хүргүүлсэн.</p> <p>ЦУОШГ-ын 2026 оны дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харьяа байгууллага болох 3 аймгийн УЦУОШТ-ийн 2024-2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх удирдамжийг батлуулсан.</p>		
60	Арга хэмжээ 6. Харьяа байгууллагуудын шилэн дансны цахим мэдээнд улирал бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Тайлангийн тоо	Тайлангийн тоо 4	2 тайланг БОУАӨЯ-нд илгээж ил тод байдлыг хангасан байна.	<p>Тус агентлагийн болон харьяа байгууллагуудын 2025 оны IV дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний үр дүнгийн танилцуулгыг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/29 тоот албан бичгээр, 2026 оны I улирлын үр дүнгийн танилцуулгыг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 01/272 тоот албан бичгээр БОУАӨЯ-нд тус тус хүргүүлсэн.</p> <p>ЦУОШГ, харьяа 25 байгууллагын www.shilendans.gov.mn сайтад байршуулсан мэдээллийн 2026 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл 99.9% хэрэгжилттэй байна.</p> <p>Ил тод байдлыг хангаж тайланг https://namem.gov.mn/p/auditdotood хэсэгт тухай бүр байршуулан ажилласан.</p>	1-6 сар	100%
Гүйцэтгэлийн зорилт 10 Цаг уур, орчны шинжилгээний газрын хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн цаг уурын байгууллагаас зохион байгуулсан хурал, уулзалтад оролцох							
61	Арга хэмжээ 1. ЦУОШГ болон түүний харьяа байгууллагуудын хэмжээнд энэ онд 500 албан хаагчийг цахим	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	120	Салбарын хэмжээнд 150 албан хаагчдыг цахим болон танхимын сургалтад хамруулсан байна.	ЦУОШГ болон харьяа байгууллагуудын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар нийт 374 албан хаагч "Байгаль орчин, нийгэм, засаглалын менежмент", "Цаг уурын нэгдсэн автомат станц", "БНХАУ-	1-6 сар	100%

	болон биечлэн хамрагдах сургалтад оролцуулах				ын эрт сэрэмжлүүлэг, хиймэл оюун ухаан”, “БНЭУ-ын зайнаас тандан судлал ба газар зүйн мэдээллийн систем”, “Уур амьсгалын тэсвэржилтийг сайжруулахад дасан зохицох хэрэгслүүдийг үр дүнтэй ашиглах нь” зэрэг гадаад улсын сургалт семинарт хамрагдсан бөгөөд үүнээс цахим хэлбэрээр 265 албан хаагч, танхимын хэлбэрээр 109 албан хаагч хамрагдсан байна.		
62	Арга хэмжээ 2. Дэлхийн цаг уурын байгууллага (ДЦУБ)-аас зохион байгуулж буй хурал, уулзалт, сургалтад оролцох	Хурал, сургалт, уулзалтад оролцох албан хаагчдын тоо	5	5 албан хаагчдыг хурал, сургалт, уулзалтад оролцсон байна.	НҮБ-ын “Эрт сэрэмжлүүлгийг иргэн бүрд” санаачилгын хүрээнд ДЦУБ, БНХАУ-ын Цаг уурын газрын дэмжлэгтэй Шанхай, Бээжин, Чиндао хотуудад 2026 оны 03 дугаар сарын 19-31, 04 дүгээр сарын 17-27, 06 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд нийт 3 удаа зохион байгуулагдсан сургалтад эхний хагас жилийн байдлаар 5 албан хаагч хамрагдсан байна.	1-6 сар	100%
63	Арга хэмжээ 3. ДЦУБ-ын II дугаар бүсийн төвөөс зохион байгуулах техникийн комиссуудын хурал, зөвлөгөөнд оролцох	Хурал, зөвлөгөөнд оролцох албан хаагчдын тоо	2	5 албан хаагчдыг хурал, сургалт, уулзалтад оролцсон байна.	БНХАУ-ын Нанжин хотноо 2026 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд ДЦУБ-ын II дугаар бүсийн төвөөс зохион байгуулсан Зуны улирлын төлөв хэлэлцэх 22 дугаар FOCRA хуралд УЦУОСМХ-ийн Хиймэл оюун ухаан, судалгааны хэлтсийн Ерөнхий технологич инженер Б.Жаргалан оролцсон.	1-6 сар	100%
Гүйцэтгэлийн зорилт 11. Цаг уур, орчны шинжилгээний газраас иргэд байгууллагуудад үзүүлдэг төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах							
64	Арга хэмжээ 1.Олон төрлийн гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх, нөлөөлд суурилсан систем болгон хөгжүүлэх, нэвтрүүлэх	систем нэвтрүүлэх үе шат, хувь	Төслөөр, туршилт судалгаа хийгдсэн	Системийг шуурхайд нэвтрүүлж туршилт хийнэ.	Хүчтэй салхи, цасан шуурга, шороон шуурга, их хүйтэн/халуун болон зудын нөлөөллийн прогнозын бүтээгдэхүүнүүдийг гаргаж вэб платформ хөгжүүлэн туршилтаар нэвтрүүлсэн. Тухайн чиглэлээр Синоптик инженерүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан бөгөөд төв, орон нутгийн синоптик инженерүүдэд зориулсан “Цаг агаарын	1-6 сар	100%

					нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ” сэдэвт сургалт нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилттэй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлт дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийн хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан.		
65	Арга хэмжээ 2. Хүлэмжийн хийн мониторингийн Улаан-Уул станцаас дээж авах	Дээж авсан тоо	Дээж авсан тоо-34	Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн мониторингийн сүлжээний мэдээг тасалдуулахгүй байх, олон нийтэд үйлчилнэ. Дээж авах тоо-52	Хүлэмжийн хийн мониторингийн Улаан-Уул станцын мэдээг 2025 оноор сунгаж, УЦУОСМХ-ийн вэб сайтаар олон нийтэд хүргэсэн. Мөн 2026 оны 1 дүгээр сарын 4 дээжийг авч, АНУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлсэн бөгөөд 2026 оны 3 дугаар сард 2 удаа дээж авахад зориулсан баллонтой хайрцгийг тус Элчин сайдын яамнаас хүлээн авч өрөөнд хадгалсан. Одоогоор хүлэмжийн хийн мониторингийн Улаан-Уул станцаас дээж авах ажил 2026 оны 1 сарын сүүлээс АНУ-ын Далай агаар мандал судлалын албаны Дэлхийн мониторингийн лаборатори (ДАТСА-ДМЛ) талаас түр зогссон байна. Хэмжилтийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах талаар АНУ-ын ДАТСА-ДМЛ-ийн цахим шуудангаар харилцан саналаа илэрхийлсэн ба шаардлагатай холбогдох мэдээллийг өгсөн. Иймд одоогийн байдлаар тус лабораториос хариу шийдвэр ирүүлэхийг хүлээж байна.	1-6 сар	100%
66	Арга хэмжээ 3. Агаарын бохирдлын загваруудын хэвийн үйл ажиллагааг хангах	Загварын бодолтын ирц	Загварын бодолтын ирц 75%	WRF-Chem загваруудаар Улаанбаатар хотын агаарын бохирдлын прогноз гаргаж, тасралтгүй үйл	WRF-Chem загварын хэвийн үйл ажиллагааг шалгаж, Улаанбаатар хотын агаарын бохирдлын прогнозын цахим хуудаст автоматаар тавигдаж байна. 2026 оны 5 дугаар сарын байдлаар 151 удаа бодолт хийхээс 148 удаа бодогдож	1-6 сар	100%

				ажиллагааг ханган ажиллах, Загварын бодолтын ирц 75.5%-д хүргэх	загварын бодолтын ирц 98%-ийн биелэлттэй байна. ADAM-Haze загварын 180 удаагийн бодолт хийхээс 169 бодолт хийгдэж 11 бодолтыг загварын 9км-ийн үр дүнгээс нөхөж бодуулав. ADAM-Haze загвар нь WRF(UM) загвараас анхны нөхцөлөө авдаг учир 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн зогссон. Иймд ADAM-Haze загварын анхны оролтыг дэлхийн хэмжээний GFS загварын үр дүнгээс авч 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс бодолт хэвийн явж байна. БНСУ-ын Цаг уурын албанаас гаргаж буй KIM загварын мэдээгээр бүс нутгийн WRF загварыг бодуулах туршилт, ADAM-Haze загварт оруулах тохируулгуудыг хийсэн.		
67	Арга хэмжээ 4. Хиймэл оюун ухаант ус цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлэх систем нэвтрүүлэх	Шуурхай ажиллагаанд нэвтрүүлэх үе шат, хувь	Хятадын системийг хүлээн авсан	Судалж, заавар боловсруулна	Хиймэл оюун ухаанд суурилсан ус, цаг агаарын гаралтай гамшигт үзэгдлийг урьдчилан мэдээлэх MAZU системд гарч байгаа асуудлуудын талаар Шанхайн цаг уурын байгууллагын холбогдох ажилтнуудтай холбогдож асуудлыг тухай бүрд нь шийдвэрлүүлж, судлах шатандаа явж байна. Зарим боловсруулалтын үе шатны асуудал одоогоор шийдэгдээгүй байна.	1-6 сар	50%
68	Арга хэмжээ 5. Монгол орны гол, мөрний усны нөөцийг тооцох	Нөөцийн тооцоонд ордог харуулын тоо	9	Гол мөрний усны нөөцийн тооцоо хийдэг 9 харуулыг нэмэх боломжийг судалж, мэдээ боловсруулсан байна.	Монгол орны гол, мөрний усны нөөцийг нарийвчлах ажлын хүрээнд ус судлалын 15 харуулын эх мэдээ бүрдүүлэх ажил хийгдэж, 9 харуулаар усны төлөв байдлыг 2025 оноор үнэлэв.	1-6 сар	100%
69	Арга хэмжээ 6. "D-LAB" цахим бүртгэл, мэдээллийн үндсэн болон дэд системийг өргөжүүлж, орон нутагт нэвтрүүлэх	Цахим бүртгэл, мэдээллийн систем ашиглаж эхэлсэн лабораторийн тоо	1	10	Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторийн үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор	1-6 сар	100%

					"D-LAB" цахим бүртгэл, мэдээллийн үндсэн болон дэд системийг хөгжүүлж, өргөжүүлэн, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2026 оны А/32 дугаар тушаалаар тус агентлагийн харьяа байгаль орчны шинжилгээний 22 лабораторийн үйл ажиллагаанд 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлсэн. https://dlab.weather.gov.mn/		
70	Арга хэмжээ 7. Байгаль орчны шинжилгээний лабораторийн итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх	Итгэмжлэлийн хүрээний үзүүлэлтийн тоо	61	-	Хугацаа болоогүй.	7-12 сар	Үнэлэх боломжгүй
71	Арга хэмжээ 8. Мөнх цас, мөсний массын гулсалтыг тодорхойлох	Судалгааны тайлан	3	Түргэн, Потанин, Цамбагаравын мөсөн голууд дээр хээрийн хэмжилт хийж, мэдээлэл бүрдүүлнэ.	Түргэн, Потанин, Хархираа мөстлийн гулсах хурдыг 2022-2025 оноор тодорхойлов. 3400м орчмын өндөрт жилд 10-30м, 3200м өндөрт жилд 5-20м, 3000м өндөрт жилд 1-8м, 2900м өндөрт жилд 0-5м тус тус шилжиж байна.	1-6 сар	100%
72	Арга хэмжээ 9. Монгол орны нуурын усан гадаргын талбайг LANDSAT-8 хиймэл дагуулын мэдээгээр тодорхойлж мэдээллийн санг баяжуулан, дүн шинжилгээ хийх	Нуурын тоо	3600	2025 оны мэдээгээр 3600 орчим нуурын усан гадаргын талбайг тодорхойлж, тайлагнана.	Монгол орны хувьд 0.003 км ² -аас их талбай бүхий 4296 нууртай ба тэдгээрийн нийт нуурын усан гадаргын талбай 15514.5 км ² байсан бөгөөд 2026 оны эхний хагас жилд 2025 оны LANDSAT-8 хиймэл дагуулын мэдээгээр 1800 нуурын усан гадаргын талбайг тодорхойлсон ба нийт усан гадаргын талбай 7835.3 км ² байна.	1-6 сар	100%
73	Арга хэмжээ 10. Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудад салхины шилжлэгийг судалж, үүсэх хүчин зүйлийг тодорхойлох	Эрдэм шинжилгээний ажлын тайлан	-	Шилжлэг салхи тохиолдсон тохиолдлуудад анализ хийнэ.	Нисэх буудлуудад салхины шилжлэгийг судалж, үүсэх хүчин зүйлийг тодорхойлж Чингис хаан ОУНБ-ын 2021-2025 он, Буянт-Ухаа ОУНБ-ын 2020-2025 оны 5 жилийн мэдээ, орон нутгийн нисэх буудлын газар зүйн байршил, 2023-2025 оны нисэх буудлын цаг уурын автомат станцын AUTO METAR-аас салхины чиглэл, хурдны давтагдал, 4-11 дүгээр сарын борооны бөөн (Cb) үүл,	1-6 сар	100%

					<p>түүнтэй холбоотой үзэгдлүүдийн давтагдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, Өлгий, Ховд, Дэглий цагаан, Отгонтэнгэр, Алтай, Мөрөн, Гурвансайхан, Мандалговь, Өндөрхаан, Чойбалсан, Баруун-Урт нисэх буудал орчмын нам өндрийн салхины шилжлэг үүсэх үеийн эрсдэлийн үнэлгээг хөөрч буух зурвасын дагуу агаарын хөлгийн арын болон угтах салхи, хөндлөнгийн салхи, борооны бөөн үүл, дуу цахилгаан, нөөлөг салхи, мөндөр зэрэг нислэгт аюултай үзэгдлийн давтагдал, тохиолдлын тоон мэдээлэл, түүнчлэн нисэх багаас мэдээлсэн агаарын хөлгийн тусгай ажиглалтын мэдээ (Pilot Report: PIREP) зэрэг холбогдох дүн шинжилгээний үр дүн, салхины шилжлэг үүсэж болох нөхцөлийг илрүүлэх туршилтад WRF цаг агаарын тоон загварыг ашигласан хэвтээ нарийвчлалыг 300м газар нутгийг 69км X 69км сонгон хэвтээ чиглэлд 600м тутамд, босоо чиглэлд аэродромын өндрөөс 1000м хүртэл 30м тутамд тоон загварчлалын үр дүнгээр урьдчилан мэдээлэх боломжийг судалж, тооцоолсон дүнгээр нам өндрийн салхины шилжлэг үүсэх эрсдэлийн үнэлгээ хийсэн. Нислэг хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, агаарын тээвэрлэгчид болон бусад хэрэглэгч нарт НЦУТ-ийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/16 тоот албан бичгийн хамт цахимаар хүргүүлсэн.</p>		
74	<p>Арга хэмжээ 11. Үүлэнд зориудаар нөлөөлөх (үйлчлэх) бүс нутгийн сүлжээ, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааны үр нөлөө</p>	<p>Тооцоолол хийгдэж үнэлгээний тайлан гарсан байна.</p>	-	<p>1-ээс доошгүй үйл ажиллагаанд үр дүнгийн тооцоолол хийгдсэн байна.</p>	<p>Үүл, хур тунадасны системд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны физик болон тоон загварчлалын судалгааны төслийг МУИС-ийн Цаг уур, ус судлалын тэнхим (ЦУУСТ)-ын дэд профессор, доктор Л.Жамбажамцын удирдлага дор</p>	1-6 сар	100%

	/агаар мандлын чийг, үүлний хөгжлийн үнэлгээг/-г радарын мэдээ ашиглан тооцох туршилтыг явуулах				Ус, цаг уур, цэвдэг судлалын лабораторитой хамтран нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төслийн санал боловсруулан хүргүүлсэн. Тус төсөл нь Шинжлэх ухааны академийн грантын санхүүжилтэд шалгарч, дэмжлэг авсан бөгөөд 2025 онд хийгдсэн 4 удаагийн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны мэдээлэлд үндэслэн анхны симуляцийн туршилтуудыг хийсэн. БНСУ-ын Цаг уурын газраас ирүүлсэн WRF загварын нэмэлт тохиргоог ашиглан WRF загварт зориудаар нөлөөлөхөд ашиглагдах тохиргоог хийж, туршив. WRF загварыг ашиглан дулаан үүлэнд кальцийн хлорид (CaCl ₂) цацах замаар зориудаар нөлөөлөх боломжийг үнэлэв. Туршилтаар цацсан бодис үүлний чийглэг бүсэд тархаж, усны жижиг дуслуудыг нэгтгэн томруулах үйлчлэл үзүүлсэн. Үүний үр дүнд загвар дахь борооны усны агууламж (QRAIN) нэмэгдэж, хур тунадас үүсэх процесс эрчимжсэн. Судалгааны үр дүн нь дулаан үүлэнд чийг татагч бодис ашиглан хур тунадсыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулсан бөгөөд цаашид WRF загварыг ашиглан Монгол орны уулархаг бүсэд ашигладаг иодот мөнгийг (Agl) цацах замаар зориудаар нөлөөлөх боломжийг судалж байна.		
75	Арга хэмжээ 12. Монгол орны хэмжээнд хэт ягаан туяаны индексийн прогноз гаргах боломжийг судлах	Тухайлсан судалгаа хийсэн байна.	Улаанбаатар хотын хэт ягаан туяаны индексийн суурь судалгааг хийсэн	Монгол орны хэмжээнд хэт ягаан туяаны индексийн прогнозын туршилт хийх хийнэ	Арга хэмжээний хүрээнд WRF загварын гаралтын үр дүнгээс хэт ягаан туяаны индексийн прогнозолх арга зүйн туршилтуудыг хийж гүйцэтгэсэн. WRF загварын гаралтаас SWDOWN, COSZEN зэрэг цацрагийн болон нарны байрлалын хувьсагчдыг ашиглан хэт ягаан туяаны индекс (UVI)-ийг тооцоолох эмпирик/ойролцооллын схем	1-6 сар	100%

					боловсруулж, грид мэдээллээс хугацааны цуваа болон зураглал хэлбэрээр прогноз гаргах туршилтуудыг гүйцэтгэсэн. Озоны мэдээг ERA5-ийн нийт багана озоны (tco3) өгөгдлөөс тогтмол/климатиологийн утгаар орлуулж, үүлшилтийн нөлөөг clearness index (SWDOWN/TOA)-ээр засварлан UVI тооцсон. Гарсан UVI прогнозын үр дүнг нарны өнцөг, озон, үүлшилтийн нөхцөлөөр харьцуулан үнэлэх, ажиглалтын UVI-тэй харьцуулалт хийх ажил хийгдэж байна		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Мэргэжлийн чиглэлээр олон улсын сургалт, мэргэжил дээшлүүлэх арга хэмжээнд хамрагдах	2	0	1	2026 оны 4-р сарын 12-18-ны өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо бүх аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн удирдлагуудын хамт орчны шинжилгээний арга зүй, менежмент, байгаль орчин, нийгэм, засаглалын талаарх сургалтад хамрагдаж гэрчилгээ авлаа.	2026.04.12-16	100
2	Арга хэмжээ 2. Байгаль хамгааллын чиглэлээр олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэх, олон нийттэй харилцах ур чадвараа дээшлүүлэх	2	0	1	- Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо (ESG)-г салбарын хэмжээнд нэвтрүүлэх санаачилга гаргаж, ЦУОШГ-ын даргын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/81 дүгээр тушаалаар Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоо (ESG)-г хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. ЦУОШГ-т 2026 оны 04 дүгээр сарын 22, 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд	2026.04.27	100

				<p>салбарын албан хаагчдад зориулсан туршлага хуваалцах сургалтыг УБ, Сөүл хотуудад зохион байгуулсан. "Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)"-ын зарчмыг олон улсын түвшинд амжилттай хэрэгжүүлж буй тэргүүлэх байгууллага болох БНСУ-ын Байгаль орчны корпораци өөрийн туршлага, ноу-хауг хуваалцах, хамтарсан төсөл, санаачилгуудыг ЦУОШГ-тай хамтран хэрэгжүүлэхээр Зөвлөх багаа ирүүлсэн. Төрийн захиргааны байгууллагад ESG-г үлгэр жишээ байдлаар нэвтрүүлж, институцийн чадавхыг бэхжүүлэх ажил явагдаж байна.</p> <p>- Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын ач тус, үр нөлөөг олон нийтэд таниулах зорилгоор өөрийн авсан шувуу, зэрлэг амьтдын гэрэл зургийг тайлбарын хамт нийгмийн сүлжээнд тогтмол нийтэлж байна. Мөн "Амьтад бидний амьдралд" гэрэл зургийн бэсрэг үзэсгэлэнг Монголын Үндэсний номын сангийн "Бүтээгч байгаль" танхимд дэлгэн үзүүлж байна.</p>	
--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА



Э.БАТТУЛГА

2026 оны 06 дугаар сарын 9-ны өдөр

Certificate of Completion

This certifies that

ERKHEMBAYAR BATTULGA

General Director,
National Agency Meteorology and the Environmental Monitoring

Has successfully completed
2026 Invitational Training Program
for the Establishment of ICT-Based Integrated
Air Quality Monitoring System in Mongolia
organized by the Korea Environment Corporation.

April 12th ~ 18th, 2026
Seoul, Republic of Korea

Korea Environment Corporation
Chairperson

LIM, SANG JUN



Ministry of Climate, Energy
and Environment



Eco Harmonist
Korea Environment
Corporation